



2017 ОН

СЕРТИФИКАТЖУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Шинээр тусгай зөвшөөрөл авч буй ББСБ-уудад зориулсан
сертификатжуулах сургалтын хөтөлбөр



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

ББСБ-ын хууль эрх
зүйн орчин

ББСБ-ын хяналт,
зохицуулалт

ББСБ-ын үйл
ажиллагаанд мөрдөгдөх
журам, заавар,
танилцуулга

ББСБ-ын нягтлан бодох
бүртгэл

Программ хангамж,
Зээлийн мэдээллийн
сан, мөнгө угаах
терроризмтай тэмцэх
тухай танилцуулга

МОНГОЛЫН БАНК БУС
САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 5-р хороолол, Сөүлийн
гудамж, 11-1 байр

www.bbsb.mn

Утас: 976 0000 9770



БАТЛАВ.
СЗХ-НЫ ДЭД ДАРГА

БАТЛАВ.
МББСБХ-НЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Д.БАЯРСАЙХАН

А.АЛТАНСҮХ

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГУУДАД ЗОРИУЛСАН
СЕРТИФИКАТ ОЛГОХ СЗХ, МББСБХ-НЫ ХАМТАРСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

ББСБ-уудын удирдлагуудад зориулсан сургалтыг зохион байгуулах үндэслэл:

2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 71 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.11-д “Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд ББСБ-ын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.” гэж заасан;

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны дүрмийн 2.1.6-д “Өөрийн гишүүдэд үйлчлэх, тухайлбал, Олон улсын болон өөрийн орны банк, Санхүүгийн салбарын холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр хангах, мэдээллийн зохих санг буй болгох, гишүүн байгууллагын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг сурталчлах, олон нийтэд таниулах, тэдгээрийн ажилтнуудыг сургалт, семинар, давтан сургалтанд хамруулах, мэргэжил дээшлүүлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны стандартуудыг тогтоож хөгжүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулах;” гэж заасан;

2014 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн 2.1.7-д “Олон нийтэд болон зохицуулалтын байгууллагуудад зориулсан сургалт, сурталчилгааг Холбоотой хамтран зохион байгуулах, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах” гэж заасан;

Цаашид Банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л ББСБ-уудын удирдлагуудыг хамруулж, сертификатжуулахыг зориж байгаа бөгөөд СЗХ-той хамтран сургалтанд хамрагдаж сертификат авсан хүмүүсийг нэгдсэн бүртгэлд оруулах ажлууд хийгдэж байгаа билээ.

Сургалтын агуулга:

Сургалтаар ББСБ-ын үйл ажиллагааны онцлог, ББСБ-ын хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалт, ББСБ-ын нягтлан бодох бүртгэл, тайлагнал, олон улс дахь бичил санхүүгийн салбарын хөгжил, өнөөгийн түвшин, бичил санхүүгийн байгууллагын нийгмийн хариуцлага, харилцагчийн үйлчилгээ, үйлчилгээний байгууллагын стандарт зэрэг мэдээллээс гадна ББСБ-уудад зайлшгүй шаардлагатай хэрэг болохуйц мэдээллийг нэг дороос өгөх зорилготой.

Сургалтын оролцогчид:

Тус сургалтанд СЗХ-ноос “ББСБ-ын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” шинээр авсан ББСБ-уудын гүйцэтгэх захирлууд, хувьцаа эзэмшигчид зэрэг компанийн дээд түвшний удирдлагууд хамрагдана.

Сургалтын хөтөлбөр: 3 өдрийн 32 кредит цагийн сургалт

№	Цаг		Сургалтын сэдэв	Агуулга	Сургагч багш
Өдөр 1					
1	09.30-09.45	15 мин	Сургалтын танилцуулга	Сургалтын хөтөлбөр, хэрэгцээ шаардлага болон ач холбогдлын талаар товч танилцуулга хийх.	МББСБХ-ны гишүүнчлэлийн хороо, гүйцэтгэх захирал Э.Ариунтөгс
2	09.45-11.15	1.5 цаг	Салбарын өнөөгийн байдал, ББСБ-ын онцлог, хууль эрх зүйн орчин.	ББС-ийн үйл ажиллагааны онцлог, төрөөс барьж буй бодлого, ББСБ-уудын үүсэл хөгжил, өнөөгийн байдал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо зээлийн үйл ажиллагааны тухай, бусад холбогдох хуулиуд.	Санхүүгийн зохицуулах хороо Банк бус санхүүгийн байгууллагын газар
	11.15-11.30	15 мин	Цайны завсарлага		
3	11.30-13.00	1.5 цаг	ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, заавар	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож, хяналт тавих журам, Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам.	Санхүүгийн зохицуулах хороо Банк бус санхүүгийн байгууллагын газар
	13.00-14.00	1 цаг	Үдийн хоолны завсарлага		
4	14.00-16.00	2 цаг	ББСБ-уудад хийгдэж буй зайны болон газар дээрх хяналт шалгалт, ББСБ-ын нягтлан бодох бүртгэл, холбогдох заавар, тайлан мэдээ ирүүлэх болон FinA систем ашиглах талаар.	ББСБ-уудад хийгдэж буй зайны болон газар дээрх хяналт шалгалтын журам, зөрчил, холбогдох журмуудын хэрэгжилтэнд анхаарах, гарч буй зөрчлийг арилгах арга замууд. ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийн онцлог, практикт гардаг алдаа зөрчил болон заавар журмын танилцуулга, анхаарах асуудлууд. Мөн холбогдох байгууллагуудад тайлан мэдээ ирүүлэхтэй холбоотой гаргадаг асуудлууд, хариуцлагын талаар.	Санхүүгийн зохицуулах хороо Хяналт шалгалт, зохицуулалтын газар
	16.00-16.15	15 мин	Цайны завсарлага		
5	16.15-18.00	1 цаг 30 мин	Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн тухай	Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн тухай, зээлийн мэдээллийн санд холбогдох боломж, давуу тал.	Монголбанк, Зээлийн мэдээллийн сан, Хяналт шалгагч Д.Төрбат

Өдөр 2					
6	09.00-10.30	1.5 цаг	ББСБ-ын эрсдэлийн төрлүүд түүний удирдлага	ББСБ-ын үйл ажиллагаанд үүсч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх удирдах арга замууд болон зээл, зээлийн үйл ажиллагаатай холбоотой учирч болзошгүй эрсдэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар танилцуулах, зөвлөгөө өгөх.	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны сургагч багш, Вишнфанд ББСБ-ын зээлийн газрын захирал Б.Цэндсүрэн
	10.30-10.45	15 мин	Цайны завсарлага		
7	10.45-12.15	1.5 цаг	Олон улсын бичил санхүүгийн байгууллагын хөгжлийн чиг хандлага	Олон улсын бичил санхүүгийн байгууллагын хөгжлийн чиг хандлага, Монгол улсын бичил санхүүгийн байгууллагын өнөөгийн түвшин, хэтийн төлөв, чиг хандлага сэдвээр танилцуулга сургалт хийх. Smart-campaign-ы үзэл санаа, танилцуулга болон бичил санхүүгийн байгууллагын нийгмийн хариуцлагын талаар сургалт хийх.	МББСБХ-ны гадаад харилцааны хорооны дарга, Вишнфанд ББСБ-ын үйл ажиллагаа эрхэлсэн захирал Э.Уянга
	12.15-13.00	45 мин	Үдийн хоолны завсарлага		
8	13.00-14.30	1.5 цаг	ББСБ-ын үйлчилгээний стандарт, харилцагчийн үйлчилгээний тухай	Үйлчилгээний байгууллагад зайлшгүй байх ёстой үйлчилгээний стандарт болон ББСБ-ын заавал мөрдөх үйлчилгээний стандартын талаар танилцуулга сургалт хийх.	Ганабелл институт, Байгууллагын зөвлөх сургагч багш
9	14.30-16.00	1.5 цаг	ББСБ-ын засаглал ба үр дүнтэй дотоод хяналтын механизмыг бий болгох нь	ББСБ-ын засаглалын ерөнхий ойлголт, сайн засаглалын нэвтрүүлэх боломж ба дотоод хяналтын тогтолцоог хэрхэн оновчтой зөв бүрдүүлэх талаар.	Монголын дотоод аудитуудын институтын ерөнхийлөгч Л.Отгонбаяр
	16.00-16.15	15 мин	Цайны завсарлага		
10	16.15-17.45	1.5 цаг	ББСБ-ын ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага, засаглалын үнэлгээний талаар	Компанийн тухай хууль болон компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн хороодын ажиллах дүрмийн талаар танилцуулах.	Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаяр
Өдөр 3					
11	09.00-10.30	1.5 цаг	Шүүх, Шүүхийн Шийдвэрийн ажиллагаа	Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай, гүйцэтгэлтэй холбогдон гарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.	Үлэмж партнерс ХНХ-ын гүйцэтгэх захирал, өмгөөлөгч С.Үлэмж
	10.30-11.30	1 цаг	Арбитр гэж юу вэ? ББСБ-ууд ашиглах боломж	Шүүхийн бус журмаар шийдвэрлэх арга зам? Арбитр гэж юу вэ? Арбитрыг үйл ажиллагаандаа ашиглах боломж сэдвээр сургалт хийх.	МҮХАҮ-ийн танхим, ОУ-ын ба Үндэсний арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга, Арбитрч Ч.Гүнждагва

	11.30-11.45	15 мин	Цайны завсарлага		
12	11.45-12.45	1 цаг	Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай	“Терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн танилцуулга, хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай танилцуулах. Мөн харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай мэдээлэл өгөх.	Монголбанк Санхүүгийн мэдээллийн алба, Хяналт шалгалтын газрын ахлах хяналт шалгагч Г.Даваахүү
	12.45-14.00	1 цаг 15 мин	Үдийн хоолны завсарлага		
13	14.00-15.00	1 цаг	МББСБХ-ны үйл ажиллагааны тухай	Холбооны танилцуулга, ББСБ-уудын үүсэл хөгжил, гишүүн байгууллагын давуу тал, цаашдын хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх.	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч А.Алтансүх
14	15.00-16.00	1 цаг	Зээлийн батлан даалтын сангийн тухай	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль болон ЗБД-ын сантай хамтран ажиллах тухай.	Зээлийн батлан даалтын сангийн Батлан даалт зохицуулалтын газрын дарга Д.Батзогсох
	16.00-16.15	15 мин	Цайны завсарлага		
15	16.15-17.00	45 мин	Хэлэлцүүлэг	Асуулт хариулт, сургалтын үйл ажиллагаатай холбоотой санал дүгнэлт.	Оролцогчид
	17.00-18.00	1 цаг	Шалгалт авч, сертификат гардуулах		

Сургалтын төлбөр: Холбооны гишүүн ББСБ бол нэг оролцогчийн 300.000 төгрөг, гишүүн бус ББСБ бол нэг оролцогчийн 400,000 төгрөг. Сургалтын төлбөрт сургалтын гарын авлага, тараах материал, өдрийн хоол, кофе брейк, сертификатны үнэ багтсан.

Сургалт зохион байгуулах огноо: Сургалтын улирал бүр тогтмол зохион байгуулна.